



ХОТЫН СТАНДАРТ, ХЯНАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 08 сарын 21 өдөр

Дугаар А/43

Улаанбаатар хот

Албан тушаалын тодорхойлолт батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Засгийн газрын 2022 оны “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн батлах тухай” 487 дугаар тогтоол, Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6, Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн “Зөвшөөрөл олгох тухай” 354 дүгээр тогтоол, Газрын дүрмийн 7.1.1, 7.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын Төрийн албаны зөвлөлөөс Албан тушаалын тодорхойлолт батлах зөвшөөрөл олгогдсоны дагуу Дотоод хяналт, шинжилгээний хэлтсийн даргын албан тушаалын тодорхойлолтыг 1 дүгээр, Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн даргын албан тушаалын тодорхойлолтыг 2 дугаар, Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын хэлтсийн даргын албан тушаалын тодорхойлолтыг 3 дугаар, Дэд бүтцийн стандарт, хяналтын хэлтсийн даргын албан тушаалын тодорхойлолтыг 4 дүгээр, Захиргаа, санхүүгийн хэлтсийн Хууль, эрх зүй хариуцсан ахлах мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 5 дугаар, Хүний нөөц хариуцсан ахлах мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 6 дугаар, Дотоод хяналт, шинжилгээний хэлтсийн Хяналт, шинжилгээ үнэлгээ хариуцсан ахлах мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 7 дугаар, Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн Барилга хариуцсан ахлах мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 8 дугаар, Дэд бүтэц хариуцсан ахлах мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 9 дүгээр, Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын хэлтсийн Ахлах мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 10 дугаар, Дэд бүтцийн стандарт, хяналтын хэлтсийн Ахлах мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 11 дүгээр, Захиргаа, санхүүгийн хэлтсийн Хууль, эрх зүй хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 12 дугаар, Хүний нөөцийн сургалт, судалгааны мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 13 дугаар, Тогтоол шийдвэрийн биелэлт хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 14 дүгээр, Тайлан, мэдээ хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 15 дугаар, Дотоод хяналт, шинжилгээний хэлтсийн Дотоод хяналт, шалгалт хариуцсан улсын ахлах байцаагчийн албан тушаалын тодорхойлолтыг 16 дугаар, Хяналт, шинжилгээ, үнэлгээний мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 17 дугаар, Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын хэлтсийн Барилгын техникийн хяналтын улсын ахлах байцаагч (барилга)-ийн албан тушаалын тодорхойлолтыг 18 дугаар, Барилгын техникийн хяналтын улсын байцаагч (барилга)-ийн албан тушаалын тодорхойлолтыг 19 дүгээр, Барилгын техникийн хяналт улсын ахлах байцаагч (хот байгуулалт)-ийн албан тушаалын тодорхойлолтыг 20 дугаар, Барилгын техникийн хяналтын улсын байцаагч (хот байгуулалт)-ийн албан тушаалын тодорхойлолтыг 21 дүгээр, Барилгын техник хяналтын улсын ахлах байцаагч (усан хангамж, ариутгах татуурга)-ийн албан тушаалын тодорхойлолтыг 22 дугаар, Барилгын техникийн хяналтын улсын байцаагч (усан хангамж, ариутгах татуурга)-ийн албан тушаалын тодорхойлолтыг 23 дугаар, Барилгын техникийн хяналтын улсын ахлах байцаагч (барилгын материал)-ийн албан тушаалын тодорхойлолтыг 24 дүгээр, Барилгын техникийн хяналтын улсын байцаагч (барилгын материал)-ийн албан тушаалын тодорхойлолтыг 25 дугаар, Барилгын техникийн хяналтын

1150500201

улсын ахлах байцаагч (өргөх байгууламж)-ийн албан тушаалын тодорхойлолтыг 26 дугаар, Барилгын техникийн хяналтын улсын байцаагч (өргөх байгууламж)-ийн албан тушаалын тодорхойлолтыг 27 дугаар, Барилга байгууламжийн хяналт хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 28 дугаар, Дэд бүтцийн стандарт, хяналтын хэлтсийн Эрчим хүчний хяналтын улсын ахлах байцаагчийн албан тушаалын тодорхойлолтыг 29 дүгээр, Эрчим хүчний хяналтын улсын байцаагчийн албан тушаалын тодорхойлолтыг 30 дугаар, Харилцаа, холбооны хяналтын улсын ахлах байцаагчийн албан тушаалын тодорхойлолтыг 31 дүгээр, Харилцаа, холбооны хяналтын улсын байцаагчийн албан тушаалын тодорхойлолтыг 32 дугаар, Авто замын хяналтын улсын ахлах байцаагчийн албан тушаалын тодорхойлолтыг 33 дугаар, Авто замын хяналтын улсын байцаагчийн албан тушаалын тодорхойлолтыг 34 дүгээр, Автотээврийн хяналтын улсын ахлах байцаагчийн албан тушаалын тодорхойлолтыг 35 дугаар, Автотээврийн хяналтын улсын байцаагчийн албан тушаалын тодорхойлолтыг 36 дугаар, Газрын тос, хийн хяналтын улсын ахлах байцаагчийн албан тушаалын тодорхойлолтыг 37 дугаар, Газрын тос, хийн хяналтын улсын байцаагчийн албан тушаалын тодорхойлолтыг 38 дугаар, Дэд бүтцийн хяналт хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 39 дүгээр, Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн Барилга байгууламж хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 40 дүгээр, Цахилгаан хангамж хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 41 дүгээр, Усан хангамж, ариутгах татуурга хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 42 дугаар, Дулаан хангамж, агаар сэлгэлт хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 43 дугаар, Тохижилт, их засвар хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 44 дүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2.Төрийн захиргааны албан хаагчийн албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийн хэрэгжилтийг “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, “Шинэ сэргэлтийн бодлого” дунд хугацааны зорилтот хөтөлбөрт дэвшүүлсэн төрийн бүтээмжийг сайжруулах зорилт, Төрийн албаны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон бусад хууль тогтоомжийн хүрээнд шинэтгэлийн үйл явцтай уялдуулан зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг холбогдох Хэлтсийн дарга нарт, Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог шуурхай нөхөн бүрдүүлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс (Э.Даваахатан)-т тус тус үүрэг болгосугай.

3.Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Хотын стандарт, хяналтын газрын даргын 2022 оны А/29 дүгээр тушаалын 4, 6, 7, 8, 13, 14, 15, 17, 26, 28, 29, 33, 34, 35 дугаар хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

4.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс (Э.Даваахатан)-д даалгасугай.

ДАРГА



С.ТӨМӨРДУЛАМ